

Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график:

Оллоо ХХК-ийн энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа МХБ болон ҮЦТТХТ ХХК-тай хийсэн гэрээний дагуу үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалах бөгөөд эхний нийлүүлэлтийг ҮЦТТХТ ХХК-ийн өөрийн данснаас 10 000 000 ширхэгийг 100 төгрөгийн үнэтэйгээр нийлүүлнэ.

Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд андеррайтер, брокер дилерийн синдикат үүсгэж санал болгох замаар хувьцааг байршуулна.

Анхдагч зах зээл дээр 2007 оны 08 дугаар сарын 22 оос 2010 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд байршуулж арилжаална.

Байршуулах үнэ:
Нэгжийн үнэ 100 төгрөг,
Нийт 1 000 000 000 төгрөг

Үнэт цаасны арилжааны мэдээг Оллоо ХХК-ийн www.olloo.mn болон МХБ-ийн вэбсайтаас (www.mse.mn) авч болно. Түүнчлэн өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон Хөрөнгө оруулалтын зөвлөх СИ СИ ПИ ХХК-иас (www.ccp.mn) арилжааны мэдээллийг авч болно.

Үнэт цаасыг арилжаалахад санал болгох хүрээ:

Дотоодын томоохон хөрөнгө оруулагч нар авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

СИ СИ ПИ ХХК-ийн хөрөнгө оруулагч нарт санал болгосон.

Хувьцааг Оллоо ХХК-ийн www.olloo.mn сайт дээр байрлуулах, олон нийтийн радио телевиз, өдөр тутмын сонингуудаар дамжуулан ард иргэд болон санхүүгийн байгууллагуудад хувьцааны тухай цуврал хичээлийг бусад ҮЦЗЗ-ийг зохицуулагч болон оролцогч байгууллагуудтай хамтран зохион байгуулж оролцоно.

Үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаар төлөвлөж байгаа бол байгуулах гэрээний төсөл, өөрөө анхдагч зах зээлд худалдах бол мэдээллийг нийтэд сурталчлах журам, төлөвлөгөө:

Оллоо ХХК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгохоос хоёр долоо хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн хувьцааг гаргах өдөр болон бусад нөхцлийн тухай мэдээлнэ.

Мэдээдлийг олон нийтэд хүргэхдээ маркетингийн үйл ажиллагааг идэвхижүүлэн доорхи үе шатуудаар дараалан арга хэмжээ авна.

Хэвлэлийн бага хурал

MN25 өнөөдөр хэвлэл мэдээллийн албатай хамтран хэвлэлийн бага хурал хийнэ.

Олон нийтэд санал болгох

	Мэдээллийн хэрэгслийн нэр	Сурталчилгааны давтамж	Бусад тайлбар
1	Өдрийн сонин	7 хоногт 3 удаа	1 удаад 27 000₮ 1/8 нүүр
2	Өнөөдөр сонин	7 хоногт 3 удаа	1 удаад 25 000₮ 1/8 нүүр
3	MTB	7 хоногт 2 удаа	1 удаад 90 000₮
4	TV9	7 хоногт 2 удаа	1 удаад 45 000₮
5	FM Элгэн нутаг	7 хоногт өдөр бүр	1 удаад 2 500₮
6	FM-101.7	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
7	FM 102.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3500₮
8	FM-104.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
9	Монголын Радио	7 хоногт өдөр бүр	1 удаад 3500₮
10	FM-98.9	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
11	FM-100.1	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
12	FM-107.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮

- Хөрөнгийн биржийн мэдээллийн албатай хамтран ажиллах,
- Өдөр тутмын сонины сэтгүүлчидэй уулзах
- Хөрөнгийн зах зээл сэтгүүлд зар тавих
- Хөрөнгийн бирж болон СИ СИ ПИ ХХК-ийн цахим хуудас дээр аноунс хийж тавих
- Арилжааны банкуудад санал болгох
- Хөрөнгө оруулагч нарт зориулсан тусгай presentation болон танилцуулга брошур бэлдэн танилцуулах,
- Томоохон хадгаламж эзэмшигч нарт
- Хувьцааны танилцуулга, брошур бэлдэн танилцуулах,
- Гадаадын хөрөнгө оруулагчдад
- Англи хэл дээр тусгай presentation болон танилцуулга брошур бэлдэн танилцуулах,